

Томуу,томуу төст өвчний үеийн өдрийн эмчилгээ,эмийн жор бичих зөвлөмж

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үе эхэлж байгаатай холбогдуулан анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүүхдэд үзүүлэх өдрийн эмчилгээг өргөжүүлэх шаардлагатай байна.

Хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчнийг эмчлэх өдрийн эмчил гээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 03 дугаар тогтоолд заасны дагуу хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчнүүдийг /**J02-J04, J09-J11, J12-J18, J20, J31**/ оношийн кодоор үзүүлдэг.

Хүүхдийн амьсгалын замын өвчний үед хүүхдийн биеийн байдал, эрсдэлт хүчин зүйл, томуу, томуу төст өвчний хэлбэрээс хамааран тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Томуу, томуу төст өвчний үед хүүхдэд өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэхэд Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/592 тушаал “Хүүхдийн өвчний цогц менежмент”, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/286 дугаар тушаалаар батлагдсан “Томуу, томуу төст өвчний эмнэл зүйн заавар”-ыг баримтална.

Эмнэлзүйн хэлбэр	Томуу, томуу төст өвчний хөнгөн хэлбэр	Халууралттай томуу, томуу төст өвчин	Хүнд ба хүндрэлтэй томуу
Онцлог шинж	Халууралтгүй, амьсгалын замын дээд хэсгийн	Халууралттай, амьсгалын замын дээд, доод хэсэг	Түргэн даамжрах явцтай уушгины үрэвсэл, амьсгалын цочмог дистресс хамшинж, үжил, олон эрхтний дутагдал
Үзлэгт	- ХӨЦМ - Эрэмбэлэн ангилалт - Томуугийн хүндэрч болох эрсдэлийг үнэлэх (эрсдэлт хүчин зүйлс, эрсдэлт бүлэг) - Тухайн хүүхдийн хувийн онцлогийг авч үзэх (суурь эмгэг, жин)		
Эрсдэлт бүлэг, хүчин зүйлсийг үнэлэх	- Бага насны хүүхдүүд, ялангуяа хөхүүл, 1 хүртэлх насны хүүхдүүд - Уушгины архаг эмгэг (багтраа) - Зүрх, элэг, бөөрний эмгэг, бодисын солилцооны эмгэг (чихрийн шижин) - Мэдрэлийн зарим эмгэг (мэдрэл булчингийн, таталт бүхий өвчин) - Дархлаа сулрах, ХДХВ, хавдар - Аспирин, глюкокортикоид удаан хугацаагаар хэрэглэх - Тарган, хэт тарган хүүхдүүд		Эрсдэлт бүлгийн хүүхдүүд томуугийн вакцинд хамрагдаагүй бол хүнд явцтай байх эрсдэлтэй

	- Олон суурь эмгэгтэй байх - Нийгмийн эмзэг давхаргын	
Эмчийн шийдвэр	- Эрсдэлтэй бүлэгт хамаарахгүй үйлчлүүлэгчийг гэрийн асаргаанд байлган эмчилгээ хийх - Томуу,томуу төст өвчний хүндрэлгүй халдвартай, бага эрсдэлтэй өвчтөнийг эмнэлэгт хэвтүүлэхгүй Анхаарах: - Эрсдэлтэй бүлгийн хүүхэд биеийн байдал хөнгөн байсан ч томуугийн түргэвчилсэн тест эерэг байвал сайтар хянаж шаардлагатай эмчилгээг хийхийн тулд эмнэлэгт хэвтүүлэх нь зүйтэй. - Давтан үзлэгийн цаг товллох	эмнэлэгт хэвтэн эмчлүүлнэ
Шинжилгээ	Томуу, томуу төст өвчний үед хурдавчилсан оношлуур эсвэл полимерагийн гинжин урвал (ПГУ)-ын шинжилгээгээр вирус тодорхойлох	
Томуугийн вирусийн эсрэг эмчилгээ	- Томуу сэжигтэй эсвэл батлагдсан бөгөөд хүнд эсвэл үгдэрч байгаа өвчтөнд (уушгины хатгалгааны шинж, үжил, эсвэл архаг өвчин сэдэрсэн) нэн даруй вирусийн эсрэг бэлдмэл хэрэглэнэ. - Зөвхөн томуугийн вирус илэрсэн тохиолдолд оселтамивирыг өвөрмөц эмчилгээний тунгаар хэрэглэх - Өвчин эхэлснээс хойш 48 цагийн дотор хэрэглэх	
Эмийн бус эмчилгээ	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/286 дугаар тушаалаар батлагдсан “Томуу, томуу төст өвчний эмнэл зүйн заавар”-ыг баримтлах	
Шинж тэмдгийн эмчилгээ	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/286 дугаар тушаалаар батлагдсан “Томуу, томуу төст өвчний эмнэл зүйн заавар”-ыг баримтлах	
Нянгийн халдвар	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/286 дугаар тушаалаар батлагдсан “Томуу, томуу төст өвчний эмнэл зүйн заавар”-ыг баримтлах	
Хөнгөлөлттэй эмийн жор	Энгийн эмийн жороос гадна эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийг цаасаар болон цахим жороор бичиж, зөвлөх	
Давтан үзлэг	Өвчин хүндэрсэн ямар нэгэн шинж илрэх эсвэл эхэлснээс хойш 72 цагийн дотор ямар нэг сайжралгүй бол эргэж үзүүлэхийг зөвлөх	

Эмчилгээ: Эмийн болон эмийн бус эмчилгээ

Эмийн эмчилгээ:

Вирусийн эсрэг эмчилгээ:

Эмнэлзүйн шинжүүд болон тархвар зүйгээр томуугийн халдварын сэжигтэй тохиолдолд шинжилгээний хариуг хүлээхгүйгээр халдвар сэргийлэлт хяналтын тогтолцоог идэвхижүүлж, вирусийн эсрэг эмчилгээг шинж тэмдэг илэрснээс хойш 48 цагийн дотор эхлүүлнэ

Томуу, томуу төст өвчний эмчилгээний удирдамжид орсон эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлж буй байгууллага, эмийн худалдааны нэршил, үнийн мэдээллийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас гаргасан

нөөцийн судалгаанд үндэслэсэн гарсан ба тус эмийг ханган нийлүүлэх байгууллагаас авч, өдрийн эмчилгээнд хэрэглэх боломжтой. Үүнд:

1. Вирусийн эсрэг эмийн эмчилгээ:

Томуу, томуу төст өвчнийг оношилохдоо түргэвчилсэн тестээр оношилж, томуу эерэг гарсан тохиолдолд Оселтамивир /тамифлу/ хэрэглэнэ.

№	Эмийн олон улсын нэршил	Эмийн худалдааны нэршил	Ханган нийлүүлж буй байгууллага /тоо/	Бөөний үнэ /ширхэгээр/ дундаж /төгрөг/
1	Осельтамивир 30мг-75мг	Элтафлу	4	3260-4140
		Юухан Н Флу		
		Тамивир		
		Оселтамир		

2. Шинж тэмдгийн эмчилгээ:

Халуун бууруулах, өвдөлт намдаах эмийн мэдээлэл:

№	Эмийн олон улсын нэршил	Эмийн худалдааны нэршил, тун	Ханган нийлүүлж буй байгууллага /тоо/	Бөөний үнэ /ширхэгээр/ дундаж /төгрөг/
1	Ибупрофен сироп, 60мл	Профен 60мл	4	9900-12400
		Нурофен 60мл		
		Миг 2% суспенз 60мл		
		Ибуфен 60мл		
2	Ибупрофен шахмал, 200мг	Ибу-Ам 200мг	3	350-820
		Нурофен 200мг		
		Ибумон 200мг		
3	Ибупрофен шахмал, 400мг	Гофен 400мг	6	442-891
		Ибупротех 400мг шахмал		
		Миг 400мг		
		Ибумон 400мг		
		Ибупрофен-Денк 400мг		
		Перофен 400мг		
4	Ибупрофен шахмал, 600мг	Ибупрофен - Денк 600мг	1	1375
5	Парацетамол лаа, 125мг	Арфен 125мг	4	520-780
		Парацетамол 125мг		
		Пара-Денк 125мг		
		РП-Парацетамол 250мг		
6	Парацетамол лаа, 250мг	Арфен 250мг	4	620-830
		Парацетамол 250мг		
		Пара-Денк 250мг		

		РП-Парацетамол 250мг		
7	Парацетамол шахмал, 500мг	Парацетамол 500мг	4	65-100

3. Амьсгалын замын цэвэршүүлэх үйлийг сайжруулах эмчилгээ:

№	Эмийн олон улсын нэршил	Эмийн худалдааны нэршил	Ханган нийлүүлж буй байгууллага /тоо/	Бөөний үнэ /ширхэгээр/ дундаж /төгрөг/
1	Амброксол сироп, 15мг/мл	Муцера 15мг/мл Амбrolитин 15мг/мл	2	682-13310
2	Амброксол тарилгын уусмал, 2мл	Ароксол 2мл	1	860
3	Амброксол шахмал, 30мг	Эпексол 30мг Муцера 30мг Флавамед 30мг	3	170-550
4	Ацетилцистеин нунтаг, 100мг	АЦЦ 100мг АЦЦ 100мг	2	865-920
5	Ацетилцистеин нунтаг, 200мг	АЦЦ 200мг АЦЦ 200мг	2	880-908
6	Ацетилцистеин нунтаг, 600мг	Флуимуцил 600 мг АЦЦ Лонг 600 мг	2	1738-1760
7	Карбоцистеин шахмал, 500мг	Карбоцистеин шахмал 500мг "ТОВА"	1	1000
8	Карбоцистеин сироп, 2%-125мл	Флюдитек 2%-125мл	1	21680

4. Антигистамины бэлдмэл:

№	Эмийн олон улсын нэршил	Эмийн худалдааны нэршил	Ханган нийлүүлж буй байгууллага /тоо/	Бөөний үнэ /ширхэгээр/ дундаж /төгрөг/
1	Кетотифен шахмал, 1мг	Кетотифен-Нахиа 1мг Профилас 1мг	2	360-490
2	Левометиризин шахмал, 5мг	Ценова-Эл уусмал 5мг Хатрик 5мг	2	560-780
3	Лоратадин шахмал, 10мг	Ремидин 10мг Лоратин 10 мг	2	690-1280
4	Хлорфенамин шахмал, 4мг	Хлорфенамин 4мг	1	210
5	Цетиризин шахмал, 10мг	Цетиризин 10мг Цетриноб 10мг	2	1980-2240

5. Антибиотик эмчилгээнд:

Нянгийн эсрэг эмийн мэдээлэл

№	Эмийн олон улсын нэршил	Эмийн худалдааны нэршил, тун	Ханган нийлүүлж буй байгууллага /тоо/	Бөөний үнэ /ширхэгээр/ дундаж /төгрөг/
1	Азитромицин хөвмөлийн нунтаг, 40мг/мл	Азитровис 40мг/мл	5	16820-17920
		Азитромицин Лек 40мг/мл		
		Азитромицин Лек 40мг/мл		
		Азилеб 40мг/мл		
		Азибиот 40мг/мл		
2	Азитромицин шахмал, 250мг	Азитро Денк 250мг	4	1640-1682
		Корзит 250мг		
		Азитро Денк 250мг		
		Азибиот 250мг		
3	Азитромицин шахмал, 500мг	Азитровис 500мг	5	4562-5860
		Азилеб 500мг		
		Азитромицин Сандоз 500мг		
		Азитро Денк 500мг		
		Азибиот 500мг		
4	Амоксациллин+клавулоны хүчил бүрхүүлтэй шахмал, 500мг+62.5мг	Амоксиклав-Денк 500/62.5	5	1545-1596
		Амоксиклав-Денк 500/62.5		
		Амоксиклав-Денк 500/62.5		
		Амоксиклав-Денк 500/62.5		
		Амоксиклав-Денк 500/62.5		
5	Амоксациллин+клавулоны хүчил ууж хэрэглэх хөвмөл бэлтгэх нунтаг, 4:1,156,25мг/5мл-50мл, 7:1, 228мг/5мг-50мл	Кмоксилин 4:1, 156.25мг/5мл 50мл	1	4,810
		Кмоксилин 7:1, 228мг/5мл 50мл	1	4,810
6	Амоксациллин+клавулоны хүчил ууж хэрэглэх хөвмөл бэлтгэх нунтаг, 125мг+31.25мг/5мл-100мл, 250мг+62.5мг/мл-100мл	Экоклав 125мг+31.25мг/5мл-100мл, 250мг+62.5мг/мл-100мл	1	22000
		Амоксиклав 125мг+31.25мг/5мл-100мл, 250мг+62.5мг/мл-100мл	1	22000-33550
7	Амоксациллин+клавулоны хүчил шахмал, капсул, 1000мг	Трифамокс Ай Би Эл Дуо 1000мг	5	1799-4000
		Вигентин 1000мг		
		Амоксиклав 1000мг		
		Амоксиклав 1000мг		

		Бетаклав 1000мг		
8	Амоксациллин+клавулоны хүчил шахмал, капсул, 375мг	Кмоксилин 375мг Моксиклав 375мг Коакт 375мг Клавомид 375мг	4	1120-1900
9	Амоксациллин+клавулоны хүчил шахмал, капсул, 625мг	Кмоксилин 625мг Моксиклав 625мг Амоксиклав 625мг Коакт 625мг Бетаклав 625мг	5	1785-2280
10	Амоксициллин капсул, 250мг	Амоксициллин 250мг Амоксициллин 250мг Моксилен 250мг Моксилеб 250мг Амоксициллин 250мг Хиконцил 250мг	6	180-480
11	Амоксициллин хөвмөлийн нунтаг, 250мг/5мл-60мл, 100мл	Амоксан 250мг/5мл-60мл, 100мл Хиконцил 250мг/5мл-60мл, 100мл Бактокс 250мг/5мл-60мл, 100мл Оспамокс 250мг/5мл-60мл, 100мл	4	11082-12310
12	Амоксициллин шахмал, капсул, 500мг	Оспамокс 500мг Моксилен 500мг Амоксициллин 500мг Хиконцил 500мг	4	260-1200
13	Кларитромицин хөвмөлийн нунтаг, 125мг/5мл	Кларидев 125мг/5мл Фромилид 125мг/5мл Фромилид 125мг/5мл Фромилид 125мг/5мл	4	19920-22200
14	Кларитромицин шахмал, 250мг	Фромилид 250мг Клартикор 250мг Кларитромицин Протех 250мг Кларем 250мг	4	970-2260
15	Кларитромицин шахмал, 500мг	Фромилид Уно 500мг Кларитромицин Протех 500мг Кларем 500мг Кларитромицин 500мг Кларитромицин 500мг	5	1571-3857

6.Томуу, томуу төст өвчний түргэвчилсэн төст

№	Эмийн олон улсын нэршил	Эмийн худалдааны нэршил	Ханган нийлүүлж буй байгууллага /тоо/	Бөөний үнэ /ширхэгээр/ дундаж /төгрөг/
---	-------------------------	-------------------------	---------------------------------------	--

1	Influenza A+B rapid test	Influenza A+B rapid test	3	1800-1600
		Influenza A+B rapid test		
		Influenza A+B rapid test		

7. Нэмэлтээр сэргээн засах эмчилгээ, утлага эмчилгээ

Эмийн болон эмийн бус эмчилгээг эхэлсний дараа хүүхдийн биеийн байдлыг 2-3 хоногт давтан үзнэ.

8. Эмийн жор бичих болон цахим жор бичих

Эмийн жор цахимаар бичихэд Эрүүл Мэндийн Сайдын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/521 тоот тушаалыг баримтлах ба Эрүүл мэндийн тухай хууль, Эм,эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Эмийн жорын маягт, жор бияилтийн стандартыг тус тус мөрдөнө.

Энгийн эмийн жороос гадна эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлттэй олгох эмийг бичиж, зөвлөх боломжтой.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/286 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхдэд тохиолдох томуу, томуу төст өвчний эмнэл зүйн заавар”-т орсон, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан эмийн жагсаалтад орсон хөнгөлттэй олгох дараах нэрийн эм байна.

Үүнд:

№	Олон улсын нэршил	Худалдааны нэр	Импортлогч байгууллагын тоо
Вирусийн эсрэг эм			
1	Осельтамивир 30мг-75мг	Элтафлу	4
		Юухан Н Флу	
		Тамивир	
		Оселтами	
Нянгийн эсрэг эм			
2	Азитромицин шахмал, 250мг	Азитро Денк 250мг	4
		Корзит 250мг	
		Азитро Денк 250мг	
		Азибиот 250мг	
3	Азитромицин шахмал, 500мг	Азитровис 500мг	5
		Азилеб 500мг	
		Азитромицин Сандоз 500мг	
		Азитро Денк 500мг	
		Азибиот 500мг	
4	Амоксациллин+клавулоны шахмал, капсул, 1000мг	хүчил	5
		Трифамокс Ай Би Эл Дуо 1000мг	
		Вигентин 1000мг	
		Амоксиклав 1000мг	
		Амоксиклав 1000мг	

			Бетаклав 1000мг	
5	Амоксациллин+клавулоны шахмал, капсул, 375мг	хүчил	Кмоксилин 375мг	5
			Моксиклав 375мг	
			Коакт 375мг	
			Клавомид 375мг	
6	Амоксациллин+клавулоны шахмал, капсул, 625мг	хүчил	Кмоксилин 625мг	5
			Моксиклав 625мг	
			Амоксиклав 625мг	
			Коакт 625мг	
			Бетаклав 625мг	
7	Амоксициллин капсул, 250мг		Амоксициллин 250мг	6
			Амоксициллин 250мг	
			Моксилен 250мг	
			Моксилеб 250мг	
			Амоксициллин 250мг	
			Хиконцил 250мг	
8	Амоксициллин/ Клавулонын 156.25мг/5мл 50мл сироп	хүчил	Кмоксилин 156.25мг/5мл 50мл	1
9	Амоксициллин/ Клавулонын 228мг/5мл 50мл сироп	хүчил	Кмоксилин 228мг/5мл 50мл	1
10	Амоксициллин шахмал, капсул, 500мг		Оспамокс 500мг	4
			Моксилен 500мг	
			Амоксициллин 500мг	
			Хиконцил 500мг	
11	Кларитромицин шахмал, 250мг		Фромилид 250мг	4
			Клартикор 250мг	
			Кларитромицин Протекх 250мг	
			Кларем 250мг	
12	Кларитромицин шахмал, 500мг		Фромилид Уно 500мг	5
			Кларитромицин Протех 500мг	
			Кларем 500мг	
			Кларитромицин 500мг	
			Кларитромицин 500мг	
Гуурсан хоолойн агчил тавиулах эм				
1	Будесонид Утлагад зориулсан хөвмөл, 0.5мг/2мл		Пулмикан 0.5мг/2мл	5
			Пульмикорт 0.5мг/2мл	
			Будесаноб 0.5мг/2мл	
2	Будесонид аэрозол, нунтаг, 200мкг-400мкг		Симбикорт Турбохэйлер 400мкг	1
3	Ипратропиум бромид утлагын уусмал, 0.5мг-2мл		Нобивент плюс 0.5мг-2мл	2
			Зенкомби 0.5мг-2мл	
5	Сальбутамол утлагын уусмал, 2.5мг/мл		Зенкомби 2.5мг/мл	3
			Нобивент 2.5мг/мл	
			Респисал 2.5мг/мл	
6	Сальбутамол шахмал, 4мг		Салброн 4мг	1
Харшлын ба анафилаксын эсрэг эм/ Антигистамин				
	Лоратадин шахмал, 10мг		Ремидин 10мг	2

1		Лоратин 10 мг	
2	Цетиризин шахмал, 10мг	Цетиризин 10мг	2
		Цетриноб 10мг	

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд эмч дараахь эрх, үүрэгтэйг анхаарна уу. Үүнд:

29.2.1.үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хэрэгцээнд нийцүүлэн оновчтой сонголт хийх, эмчилгээний үр дүнд эргэн хяналт тавих;

29.2.2.эмийн тун, хэмжээ, хэрэглэх арга, эмчилгээний үргэлжлэх хугацаа, илэрч болзошгүй гаж нөлөө, харилцан үйлчлэлийн талаар үйлчлүүлэгчид тайлбарлах;

29.2.3.эмийн гаж нөлөөг хянах, тухай бүр мэдээлэх;

29.2.4.эмийг эмийн жорын стандартын дагуу бичих;

9. Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид эмнэлгийн хуудас олгох талаар:

Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн үед эцэг, эх, асран хамгаалагчдад эмнэлгийн хуудсыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/177, А/433 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт болох “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-аар олгоно.

Эмнэлгийн хуудас олгох үндсэн нөхцөл:

1. Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 0–6 хүртэлх насны хүүхэд (зарим тохиолдолд 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд);

2. Өрх, сум, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмчийн үзлэгт хамрагдан амьсгалын замын үрэвсэлт өвчнөөр оношлогдсон;

3. Томуу, томуу төст өвчний халууралттай хэлбэр, өвчин үгдрэн хүндэрч байгааг илтгэх шинж тэмдгүүд илрэх үед;

4. Давтан үзлэгийн үед эмчийн дүгнэлтээр өвчний явц, хүндрэл үүссэн, эцэг эх асран хамгаалагчийн хяналтанд эмчилгээг үргэлжлүүлэх шаардлагатай үед;

--- оОо---